

СОЦИАЛИЗМ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХЯТАДЫН ЭРДЭМТДИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ц. Пүрэвжаргал

ХКН-ын XIII их хуралд тавьсан (1987 оны 10 дугаар сар) Төв Хорооны тайлан илтгэлд «БНХАУ социализмын эхний шатанд байгаа бөгөөд энэ шат нь 1950-иад оны дунд үеэс авч бодоход 100 жил үргэлжилнэ» гэдгийг онолын үүднээс зааж түүний онцлог, зорилт, хэрэгжүүлэх арга замын тухай тодорхойлсон билээ. Социализмын «эхний шатны» үзэл баримтлалыг дэвшүүлснээр Хятадад социализмыг шинээр ойлгож, түүнд шинээр хандах болж нийт социалист орнууд зөвлөлтийн туршлагыг нэгэн үедээ механикаар хуулбарласан 40---50-иад оны хөшүүн загварыг хянан үзэж, түүний оронд «социалист төлөвлөгөөт таваарын аж ахуйн» загварыг бий болгож байна. Энэ нь өмч, аж ахуйн хэвшлийн янз бүрийн хэлбэрийг (улсын болон хорооллын хэлбэртэй нийгмийн өмчийн давамгайлах үүргийг хэвээр хадгалж, эрх тэгш үзэх, таваар мөнгөний харилцаа, зах зээлийн механизмыг өргөнөөр ашиглах, төлөвлөлт удирдлагыг хатуу төвлөрүүлэхээс татгалзахыг шаардаж байгаа юм. Ер нь социализмыг хэрхэн үзэх, түүнд шинээр яаж хандвал зохих болон социалист орнуудад хийж буй өөрчлөлтийн тухай хятадын эрдэмтдийн үзэл баримтлалын талаар хураангуйлан авч үзвэл:

Нэг. Социализмыг дахин ойлгох, уламжлалт социализмаас орчин үеийн социализмд шилжих нь

Өнөөгийн эрин үе бол дэлхийн социализм ч, дэлхийн капитализм ч уламжлалт хуучин байдлаасаа орчин үеийн шинэ байдалд шилжих үйл явц ид өрнөж байгаа үе гэж үзэж байна. Иймд орчин үед социализм, капитализмын тухай ойлголт, тэдгээрийн хоорондын харилцааг шинэлэг сэтгэлгээгээр бодитой авч үзэх нь зүйтэй юм. Энэ нь социализмын хөгжлийн түүхэн замнал, тохиолдсон бэрхшээл, сөрөг үзэгдэл, алдаа завхралын сургамжид үндэслэн хийсэн шинэ дүгнэлт гэж хятадын эрдэмтэд нотлож байна.

ХКН-ын Төв Хорооны дэргэдэх намын сургуулийн шинжлэх ухааны социализмын тэнхимийн эрхлэгч, профессор Жао Яогийн үзэж байгаагаар, хагас зуу гаруй жилийн туршид Сталины дэвшүүлсэн социализмын гурван чухал онцлог болох нийгмийн өмч, хийсний хирээр хуваарилах зарчим, төлөвлөгөөт эдийн засгийн онолд хүмүүс хэт автагдан, хуулбарлан үгширтэл баримтлах явдал газар авч, оюун санааны шинэ сэтгэлгээ хөгжихгүй, социализмыг онолын хувьд алдаатай ойлгож иржээ. Ингэснээр бүгдийг «бүх нийтийн» болгох, хуваарилалтыг тэгшитгэлээр» солих, аж ахуйг хөтлөх ажилд өрөөсгөлөөр хандах болж улмаар алдаж онох зэргээр Хятадын хувьд муруй тахир замаар явж ирсэн байна. Өөрөөр хэлбэл ЗХУ-ын дараа социализмын замд орсон орнуудын хувьд тэдний түгээмлээр дагах загвар нь зөвлөлтийн эдийн засаг, улс төрийн систем байв.

Гэхдээ ЗХУ-ын хувьд гэвэл нэг хэсэгтээ дэлхий дээр өнчин арал лугаа адил социалист цорын ганц орон байсан үедээ хүний болон материал, санхүүгийн хязгаарлагдмал хүч нөөцийг зайлшгүй шаардлага

тай зүйлд оновчтой зөв ашиглах, социалист бүтээн байгуулалт, улс эх орноо батлан хамгаалахад тэдгээрийг үр ашигтай зарцуулахын тулд нийгмийнхээ эдийн засаг, улс төрийн системийг тухайн үедээ хатуу төвлөрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байлаа гэж Жао Яо дүгнэсэн байна. Үүний дүнд 1917—1936 оны хоорондох 19 жилийн дотор ЗХУ-ын нийгмийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ дэлхийд 6-р байранд байснаа 3-р байранд оржээ. Мөн 1950 онд ЗХУ-ын үндэсний орлого тэр үеийн АНУ-ын үндэсний орлогын 31 хувьтай тэнцэж байсан бол 1979 онд 67 хувьтай нь тэнцэх болсон байна. Одоо ЗХУ эдийн засаг, улс төр, цэргийн хүчний хувьд АНУ-ыг тогтоон барьж байх бололцоотой болсон гэж Хятадад үзэж байна. Нөгөө талаар Зөвлөлтөд мөрдөж ирсэн систем нь БНХАУ болон социалист бусад орныг эдийн засгаа өөд татаж хөгжүүлэх, социалист үйлдвэржүүлэлт явуулахад мөн түлхэц өгсөн ажээ. Гэвч зөвлөлтийн хэв загвар бол өө сэвгүй, аль ч улс орны хувьд таарч тохирох хэв маяг биш, олон дутагдал доголдолтой байв гэж үнэлж байна. Тухайлбал энэхүү системийн үед улсын албан байгууллагын ажилтны хүнд суртал, дураараа авирлах, мухар сохроор удирдах буюу захиргаадах, хувийн эрх ашиг хөөцөлдөх, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг муу арга барилыг зуршил болгосноос гадна аж ахуй, үйлдвэрлэлийг хөтлөн удирдахад ч учир дутагдалтай, үйлдвэрлэлийн дотоод хүч нөөц тааруу, үйлдвэрлэлийн үр ашиг доогуур, бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, чанар муу, хүмүүсийн эрэлт хэрэгцээг хангахгүй байлаа гэж дүгнэжээ. Социализмын хөгжлийн олон жилийн өнгөрсөн практикаас үзэхэд эхлээд ЗХУ дараа нь БНХАУ, Зүүн европын зарим социалист орон, Ази, Европын социалист орнууд өөрийн түүхэн хөгжлийн онцгой нөхцөлд социализмын уламжлалт загвар тогтоож улмаар дэлхийн социализмын хөгжилд ноцтой саад тотгор учруулсан гэнэ. Иймээс өнөөдөр социалист орнууд өөрчлөлт шинэчлэлтээр дамжуулан хуучин уламжлалт социализмын загварыг өөрчилж орчин үеийн шинэ социализм байгуулах асуудлыг нухацтай авч үзэж гүн гүнзгий судалж хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд үүний тулд дараах асуудлыг анхаарвал зохих ажээ.

Энэ зууны 20, 30-аад оноос 40, 50-иад он хүртэл хүмүүс социализмыг бүрэн ойлгохгүй, зөвлөлтийн загварыг социализмын цорын ганц хэв маяг гэж үзэж түүнийг л хуулж, дагаж дууриавал сая социализмыг байгуулж байна гэж үздэг байсан. 1948 оноос Зөвлөлт, Югославын харилцаа муудаж, Югослав улс даралтад орсноос бие даасан социализмын загварыг эрж хайж эхлэв. 1950-иад оны дунд үеэс хойш Европ, Азийн хэд хэдэн улс орон социализм байгуулах практикийнхаа явцад, зөвлөлтийн социалист байгуулалтын хэв загвар нь тэдгээр орны үйлдвэрлэлийн хүчин чадлыг хөгжүүлэхэд садаа болж буйг мэдэрч, өөрчлөлт шинэчлэлт шаардагдсан бөгөөд энэхүү өөрчлөлтийг гагцхүү нэг загвараар бус, өөрийн улсын дотоод байдалтай холбон явуулах нь зүйтэй юм байна гэдгийг ухамсарлаж, улс орныхоо онцлогт тохирсон социализмын загварыг хайх болсон юм. Ийнхүү хүмүүсийн ярьдагчлан югославын загвар, унгарын загвар, польшийн загвар, румыны загвар, хятадын загвар зэрэг бий болжээ. Тэгээд алс хэтдээ социалист нийгэм хөгжихийн хирээр социализмын загвар улам олон болох ёстой хэмээн үзэж байлаа. Гэвч тийм байдалд хүрээгүй юм.

Эдүгээ социализмын олон янзын загварыг нэгтгэж нэгдмэл болгох нэг чухал асуудал бол социализмын загварын өөрчлөлтийн тухай асуудал, өөрөөр хэлбэл уламжлалт социализмаас орчин үеийн социализмд шилжин орох явдал болж байна.

Марксизмын түгээмэл үнэнийг тухайн улс орны бодит практиктай хосолж, өөрийн өнгө аястай социализмын замаар замнаж, өөрийн өвөрмөц социализмын загварыг бий болгох нь хувьсгалт үйл явц болон бүтээн байгуулалтын үйлсэд амжилт олох хамгийн үндсэн нөхцөл, гол баталгаа мөн гэж Хятадад үзэж байгаа болно.

Уламжлалт социализмаас орчин үеийн социализмд шилжих гол хэмжүүр, хэм хэмжээ юу вэ гэдгийг хятадын эрдэмтэд дараахи байдлаар тодорхойлж байна.

1. Өмчийн хувьд, өнөө хүртэл уламжлагдан ирсэн дан ганц цэвэр нийгмийн өмчөөс олон төрөлт аж ахуйн хэсгээс бүрэлдсэн нийгмийн өмчид шилжих. Нийгмийн өмчийн хувьд, уламжлалт бүх ард түмний болон хоршооллын гэсэн хоёр хэлбэрээс гаргаж үйлдвэрлэлийн хэрэгслийн хөгжлийг хурдасгаж чадах эрэл хайгуул хийж өмчийн ашигтай шинэ хэлбэрт шилжих. Хятадын нийгмийн шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ли Гогуаны үзэж байгаагаар социалист таваарын аж ахуйн хөгжил нь юуны өмнө үйлдвэрүүдийг хараат бус үйлдвэрлэгч болгон өөрчлөхийг шаарддаг байна.

2. Хуваарилалтын хувьд, хийсний хирээр хуваарилах гэдэг нэрийдлээр «тэгшитгэж», нэг «том тогооноос» хооллодгийг больж, жинхэнэ хийснийх нь хирээр хуваарилах социалист зарчмыг гол болгосон хуваарилалтын олон төрөлт аргад шилжих. Жишээлбэл, төлөвлөгөөт таваарын аж ахуйн зарчмын үндсэн дээр хуваарилалтын механизмыг дахин хянаж, орлогын хуваарилалтыг зах зээлээр зохицуулж болох талтай. Таваарын аж ахуйн нөхцөлд хийсний хирээр хуваарилах зарчим нь ажиллах хүчний өртөгтэй, эсвэл ажиллах хүчний талаархи зах зээлийн хэрэгцээтэй зэрэгцэн холбогдож байх. Иймд хөдөлмөрлөсний хирээр хуваарилах шинэ механизм нь мөн чанартаа зах зээлийн механизм ажээ.

3. Эдийн засгийн хэв загварын хувьд, уламжлалт үйлдвэрлэлийн эдийн засгаас таваарын эдийн засагт шилжих. Хэрэглээний зүйл төдийгүй, үйлдвэрлэлийн хэрэгсэл таваар болж болох ба тэдгээрийн зах зээл ч гэж байх ёстой. Зах зээлийн тухай үзэл баримтлал нь үнийн бодлоготой нягт холбоотой. Зөвхөн улс барааны үнийг тогтоож зохицуулах ёстой гэсэн ойлголтыг өөрчилж үнийн нэг хэсэг нь зах зээлээр зохицуулагдах ёстой гэж үзэх.

4. Төлөвлөлтийн системийн хувьд, уламжлалт төлөвлөгөөт эдийн засгийг баримталж, зах зээлийн зохицуулалтыг үгүйсгэдэг үзлээс антижирч төлөвлөгөө, зах зээлийн зохицуулалтыг хослох аргад шилжих. Төлөвлөгөө удирдамжийн шинж чанартай, улс ардын аж ахуйн салбарыг бүхэлд нь хамарсан, бодит үзүүлэлтүүдийн систем байх ёстой гэдэг үзлийг орхиж төлөвлөгөөт удирдлага нь индикатив төлөвлөлт маягаар хэрэгжих, төлөвлөлтийн гол нь макро эдийн засгийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх ба бүтэц салбарын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

5. Аж ахуйн төрөл, хэлбэрийн хувьд, эдийн засгийн хаалттай уламжлалт аргаас эдийн засгийн нээлттэй бодлого явуулах аргад шилжих. Дэлхийн нийгмийн өөр өөр байгуулалтай улс орнуудын хооронд зөрчил бэрхшээлтэй, хурц асуудлууд байгаа боловч эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаа солилцоо улам хөгжиж дэлхий ертөнц харилцан шүтэлцээтэй, улам бүр салшгүй нэгэн бүхэл бүтэн бие цогцос болж байгаа учир орчин үеийн социализм ч нээлттэй дэлхий ертөнцийн шаардлагад нийцэх ёстой.

6. Удирдлагын системийн хувьд, уламжлалт төвлөрсөн удирдлагын аргаас ангижирч, дээрээс удирдахыг гол болгодоогоо больж доод шатны байгууллагуудад бие даасан эрх мэдэл олгох аргад шилжих.

Эдийн засгийг хөтлөн явуулах аргын хувьд уламжлалт засаг захиргааны аргаас эдийн засгийн удирдлагын аргад шилжих. Үүний тулд эдийн засгийн хөшүүргийн үүрэг ролийг бүрэн ашиглаж, дан ганц олон түмний хүсэл зоригт тулгуурладаг уриа, лоозонгийн аргаас хувь хүмүүсийн материаллаг сонирхолыг анхаарах аргад шилжих.

7. Төрийн хувьд, уламжлалт хүчирхэг диктатурын дарангуйлах систем, захиргаадах, хүнд суртлын аргаас ардчилал, ил тод байдлыг өрнүүлэх аргад шилжих.

8. Нам, төр, нийгмийн бүлгийн харилцааны хувьд нам захиргааны ажлын нэгдсэн уламжлалт аргаас нам, захиргааны ажил үүргийг зааглан салгах аргад, төр олон нийтийн байгууллагын үүрэг ролийг өрнүүлэх арга барилд шилжих.

Намын дотоод зохион байгуулалт болон намаас улс орны улс төрийн амьдралд үзүүлэх нөлөөний хувьд гэвэл намын удирдлагыг дагаж баримтлах уламжлалаас юуны өмнө намын удирдан чиглүүлэх ролийг төгөлдөржүүлэн боловсронгуй болгох, тодруулж хэлбэл, нам өөрөө өөрчлөгдөх аргад шилжих.

9. Боловсон хүчин, хүнийг үнэлэхийн хувьд, хүний хүчин зүйл, түүнд тавих анхаарал халамжийг үл ойшоодог байсан уламжлалаас хүний талаар сэтгэл гаргаж, анхаарал халамж тавих, хүний хүчин зүйлийг үнэлэх, хүний эрхийг хүндэтгэх аргад шилжих нь зүйтэй гэж үзэж байгаа болно.

Энэ бүгдийн дүнд бүхэлд нь авч үзвэл, одоо аажмаар байгуулж байгаа шинэ, орчин үеийн социализм нь өндөр үр ашигтай, амьдрах их чадвартай, хөгжих өргөн дэлгэр ирээдүйтэй систем байх ёстой аж. Мөн энэ нь баян чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншил бүхий, шударга, тэгш эрхтэй, энх тайван, социалист байгуулалтын систем байх бөгөөд маш урт удаан хугацааны замыг туулж байж хэрэгжинэ. Чухамхүү орчин үеийн ийм социализм л орчин үеийн капитализмтай түүхэн уралдаан хийх чадвартай юм гэж тодорхойлж байна. Энэ үүднээс ч социалист орнуудад өөрчлөлт шинэчлэлт хийж байна тэж Хятадын эрдэмтэд үзэж байна.

Хоёр. Социалист орнуудад хийж буй өөрчлөн байгуулалтын тухай Хятадын үзэл хандлага

Социалист орнуудын шинэчлэлт, өөрчлөлт хэрэв 1950-иад оноос Югославаас эхэлсэн гэвэл 39 жил, хэрэв 1956 оны ЗХУКН-ын XX их хурлаас И. В. Сталиныг шүүмжилснийг тооцвол өнөөдрийг хүртэл 34 жил боллоо. Гэвч амжилт олж, үлгэр дууриал үзүүлж чадаагүй гэж үзэж байна.

БНХАУ-д өөрчлөлт хийгээд 10 жил болсон бөгөөд түүний зорилго нь нийгмийн амьдралыг ардчилах, нам, төрийн байгууллагын үүргийг зааглах, үр ашгийг нь дээшлүүлэх, ард түмний улс төрийн ухамсар, идэвхийг өрнүүлэх, аж амьдрал, соёлынх нь түвшинг эрс дээшлүүлэх, үйлдвэрлэх хүчний хөгжлийн зам дахь саадыг арилгах, улс орны эдийн засгийг найдвартай хөгжүүлж, хөгжлийн шинэ шатанд гарахад оршиж байна.

Хятадын эрдэмтдийн үзэж байгаагаар 1980-аад оноос, ялангуяа сүүлийн 2—3 жилд социалист орнуудад хийж буй өөрчлөн байгуулалт амжилтад хүрч байгаа бөгөөд дор дурдсан хэд хэдэн нийтлэг онцлог шинж байгаа ажээ. Үүнд:

1. Өөрчлөн байгуулалт түгээмэл шинжтэй байна. Өөрчлөн байгуулалт Европ, Азигүй тархаж жижиг улсаас аваад БНХАУ, ЗСБНХУ зэрэг хоёр том гүрнийг хамрав. Ази тивийн Монгол, Вьетнам, Лаос,

Латин Америкийн Кубад ч мөн өөрчлөн байгуулалт хийж байгаа ба гагцхүү өөрчлөн байгуулалтын хурдац, үр дүн жигд бус байна.

2. Өөрчлөн байгуулалт бүх талыг хамарсан шинжтэй байна. Өөрчлөн байгуулалт социалист орнуудын зөвхөн эдийн засгийн салбарыг хамраад зогсохгүй мөн улс төр, цэрэг арми, шинжлэх ухаан, соёл боловсрол, хэвлэл мэдээлэл зэрэг амьдралын бүх салбарыг хөндөж байна. Мөн улс орнуудын дотоод амьдралын асуудал төдийгүй гадаад харилцааны асуудлыг ч хамарч байгаа учир дотоод, гадаад бодлогод зохицуулалт хийх шаардлага тулгараад байна.

3. Өөрчлөн байгуулалт гүн гүнзгий шинж чанартай байна.

Өөрчлөн байгуулалт улам бүр гүнзгийрэн өрнөж социализмын үндсэн зарчмын асуудлыг зүй ёсоор хөндөж байна. Тухайлбал өөрчлөлтийн явцад социализм нь улс төр, эдийн засаг, үзэл суртал, соёлын хувьд олон янз байж болох эсэх, коммунист нам зонхилох эрхтэй байх эсэх, нам, төрийн ажил үүргийг зааглах эсэх, нийгмийн өмч хувийн өмч зэрэгцэн оршиж болох эсэх, нийгмийн өмчийн үндсэн дээр таваарын аж ахуйг хөгжүүлж болох эсэх, төлөвлөлтийг зах зээлийн зохицуулалттай хослох эсэх, гадаадтай хөрөнгө хорших эсэх, дэлхийд хоёр систем удаан хугацаанд оршиж чадах эсэх, энх тайванч уралдаан өрнөх эсэх зэрэг асуудал гарч нэлээд нь зохистойгоор шийдвэрлэгдээд байна. Шийдвэрээ хүлээж буй асуудал ч байна.

4. Өөрчлөн байгуулалт бие даасан шинжтэй байна.

Социалист бүх орны өөрчлөн байгуулалт тусгаар тогтносон, бие даасан, тэгш эрхийн үндсэн дээр харилцан суралцах, туршлага солилцох, сургамж авах замаар урагшилж байна. Улс орнууд тусгаар тогтнол, бие даасан байдлаа цохон тэмдэглэж өөрийн улсын бодит байдлыг үндэслэн өөрчлөлт хийхийг чухалчилж байна. Үүний зэрэгцээ өөрчлөлтийн явцад ЗХУ болон Зүүн Европын социалист орнуудын харилцаа тэгш эрхийн үндсэн дээр хөгжих чиглэлд орж, Хятад болон Зөвлөлт, Зүүн Европын социалист орнуудын харилцаа хэвийн болж байна. Социалист орнуудын хооронд энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр шинэ маягийн харилцаа тогтож, олон улсын байдал сөргөлдөөнөөс намжмал байдалд шилжиж байгаа нь социалист орнуудад өөрчлөн байгуулалт явуулах олон улсын таатай нөхцөлийг бүрдүүлэн өгч байна

Энэ бүгдээс үзэхэд 80-аад оны өөрчлөлт шинэчлэлт нь хүрээ, далайцаараа 50, 60, 70-аад оны үеийнхээс хол давж, дэлхийн эргэлт буцалтгүй үйл явц болж байна гэж хятадын эрдэмтэд дүгнэж байна. Гэхдээ өөрчлөлтийн явцад анхаарахгүй байж болохгүй, өмнө нь тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд олон байна гэж үзэж байгаа юм. Үүнд:

1. Өөрчлөн байгуулалтын явцад социалист орнуудын хөгжлийн тэгш бус харьцаа ихэсч байна. Зарим оронд өөрчлөлт үр дүн, ашгаа түргэн өгч байхад заримд нь удаан өгч байна. Зүүн Европын социалист орнууд үйлдвэржүүлэлт явуулсан байхад Азийн хэд хэдэн хөгжиж буй социалист орон цөмөөрөө уламжлалт үйлдвэржүүлэлт хийгээгүй байна. Зөвлөлт болон Зүүн Европын социалист орнуудын нэг хүнд ногдох үндэсний орлогын дээд хэмжээ 4000 ам. доллар доод тал нь 1500 ам. доллар байхад Азийн социалист орнуудаас нэг хүнд ногдох үндэсний орлогоороо хамгийн их нь Монгол улс (1200 ам. доллар), хамгийн бага нь Вьетнам, Лаос (100 ам. доллар) байх жишээтэй. Азийн эдгээр орны түүх, соёлын уламжлал, шашин шүтлэг, амьдралын хэв янз, зан заншил нь ЗХУ, Зүүн Европын орнуудаас эрс ондоо болно.

2. Өөрчлөлтийн явцад Югослав, Унгар, Польш зэрэг орны эдийн засагт ноцтой бэрхшээл учирч гол нь барааны үнэ өсч, мөнгөний ханш буурч байна. Дээрх орнуудын гадаадад төлөх өр ихэссэнээр зарим улсынх нь ард түмний амьдралын түвшин буурч байна.

3. Өөрчлөлтийн явцад намын дотоод, гадаад үзэл суртал замбараагүйтэх байдал газар авч байна. Зөвлөлтөд гэхэд улс төрийн бүтцийн өөрчлөн байгуулалт сайн явагдаж байгаа боловч үндэстнүүдийн хоорондын зөрөлдөөн ихэсч, эдийн засгийн өөрчлөлтийн үр дүн мэдэгдэхүйц харагдахгүй байна.

4. Югославчууд өөрчлөлт шинэчлэлт амжилтад хүрэхгүй байгаагаа урьд өмнө эдийн засаг, улс төр, намын гэсэн гурван төрлийн өөрчлөлтийг харилцан уялдаагүй, салангид хийснээс болсон гэж үзэж байна. Унгарын тал ч өөрчлөн байгуулалтын гол сургамж бол эдийн засгийн шинэчлэлийг улс төрийн шинэчлэлтэй холбоогүй явдал гэж үзэв.

5. Өөрчлөн байгуулалтын явцад, олон намын систем байж болох эсэх талаар маргаан явагдаж, бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа энэ асуудал 1988 онд социалист олон оронд яригдав. Унгар улс олон намын системийг зөвшөөрсөн ба Зөвлөлтөд ч энэ асуудал сөхөгдөж байна. ЗХУ-д, цөөн бус хүн олон намын систем байх нь зүйтэй гэж үзэж байгаа ажээ. Польш, Чехословак, Ардчилсан Герман Хятад зэрэг олон намын системтэй орнууд нь урт удаан хугацааны туршид эрх барих нам нь бусад намтайгаа хамтран ажиллаж улс орныг өөрөө удирдаж ирсэн уламжлал, туршлагатай юм. Социализмын хөгжлийн шатанд таваарын эдийн засгийг хөгжүүлэх хэрэгтэй учраас энэ нөхцөлд нийгмийн өөр өөр анги, давхаргын сонирхол нэгдэж чадахгүй тул олон нам байх нь зүйтэй гэж зарим хүн үздэг байна.

6. Одоо Зөвлөлт, Унгар, Югославт намын дотоод, гадаад бодлоготой холбогдсон асуудлаар хийж буй төрөл бүрийн хурал, зөвлөлгөөн дээр хүмүүсийн хэлж буй үг, хэвлэлд нь нийтэлж буй материалаас үзвэл өөрчлөн байгуулалтын асуудлаар санал хуваагдаж буй нь харагдаж байна. Лениний үеийн олон арга барил, үзлийг сэргээн мөрдөх тухай ярьж байгаа хэдий боловч бэрхшээлүүд тулгарсаар байна.

Цаашид анхаарч шийдэх ёстой асуудал гэвэл: Өөрчлөн байгуулалтын явцад гол нь эдийн засгийн өөрчлөлт биш харин улс төрийн өөрчлөлт хийх нь чухал юм. Ингэснээр нэгэнт тогтсон удирдлагын хэт төвлөрлийг арилгаж улмаар улс төрийн системийн бүтэц нь аяндаа эдийн засаг, соёлын болон бусад салбарын өөрчлөлтийн явц, үр дүнд нөлөөлөх тул юуны өмнө улс төрийн бүтцийн шинэчлэл хийх нь хамгаас чухал байна. Өнөөгийн практикт социалист орнуудын эрх барих намын их хурал 5 жилд нэг удаа хуралдаж байгаа нь хугацаа нь хувьд хэт зайтай учир завсарт нь намын бага хурал хийж байх нь зүйтэй гэж хятадын хэвлэлд бичиж байна.

Социализмыг шинээр ойлгох социалист орнуудад хийж буй өөрчлөн байгуулалтын талаархи хятадын эрдэмтдийн үнэлэлт, үзэл баримтлал ийм байна. Гэхдээ энд онолын болон практик шинжтэй, маргааны чанартай шийдэгдээгүй асуудал ч байгаа нь тодорхой юм.

Ийнхүү БНХАУ социализмд шинээр хандах болсон нь социализмын зарчмуудаас ямар нэг талаар татгалзаж байгаа хэрэг биш бөгөөд харин ч түүнийг улам боловсронгуй болгоход чиглэж байгаа юм. Хятад улс социализмын замаас хэзээ ч ухрахгүй гэдгээ хятадын удирдагчид намынхаа XIII их хурал дээр нотлон заасан билээ.